



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/41/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитор: О.Хэрлэнзаяа
Утас: 70357955 Цахим хаяг: Kherlenzayao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.08.25 № 90
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН 7 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.ЭНХСАЙХАН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>122,873,273.87</u>	<u>127,861,790.39</u>
33	АВЛАГА	-	51,596.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	51,596.52
35	БАРАА МАТЕРИАЛ	122,873,273.87	127,810,193.87
351	Түүхий эд материал	112,860,622.80	116,785,472.80
35110	Тусгай зориулалттай материал	112,669,322.80	116,599,372.80
35130	Эм боох материал	191,300.00	186,100.00
354	Хангамжийн материал	10,012,651.07	11,024,721.07
35410	Бичиг хэргийн материал	2,135,400.00	800,650.00
35420	Аж ахуйн материал	1,065,800.00	3,571,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,019,300.00	-
35450	Барилгын засварын материал	1,851,900.00	1,746,900.00
35460	Хүнсний материал	-	965,120.00
35470	Бусад хангамжийн материал	3,940,251.07	3,940,251.07
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,089,841,586.16</u>	<u>4,999,267,592.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,089,841,586.16	4,999,267,592.00
392	Биет хөрөнгө	4,535,012,211.09	4,444,506,966.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,163,311,859.26	4,163,311,859.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	(194,962,001.36)	(258,397,676.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	437,422,936.66	436,988,136.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(78,988,301.86)	(93,524,253.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,717,658.95	72,164,314.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(73,327,704.49)	(65,817,887.27)
39209	Зам, гүүрийн байгууламж	221,105,795.12	221,105,795.12
39210	Хуримтлагдсан элэгдэл	(20,268,031.19)	(31,323,320.93)
393	Биет бус хөрөнгө	554,829,375.07	554,760,625.09
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(240,624.93)	(309,374.91)
39303	Бусад биет бус хөрөнгө	554,520,000.00	554,520,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,212,714,860.03</u>	<u>5,127,129,382.39</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,212,714,860.03</u>	<u>5,127,129,382.39</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>5,212,714,860.03</u>	<u>5,127,129,382.39</u>
512	Хуримтлагдсан үр дүн	1,664,185,160.77	1,578,599,683.13
51210	Өмнөх үеийн үр дүн	1,664,185,160.77	1,664,185,160.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	(85,585,477.64)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,493,476,079.21	2,493,476,079.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,212,714,860.03</u>	<u>5,127,129,382.39</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,634,942,510.00	712,022,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,929,760,710.00	5,714,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,929,760,710.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,929,760,710.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,929,760,710.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		5,670,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө-Бараа материал		43,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	705,181,800.00	706,308,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	636,759,300.00	641,016,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	636,759,300.00	641,016,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	315,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,422,500.00	64,477,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,422,500.00	64,477,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	872,234,325.39	797,607,977.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	872,234,325.39	797,607,977.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	870,914,135.73	794,929,436.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,547,500.00	526,336,569.55
210101	Үндсэн цалин	343,261,240.62	350,542,085.80
210102	Нэмэгдэл	132,587,446.03	133,601,066.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,406,995.82	1,137,200.00
210104	Урамшуулал	36,291,817.53	41,056,217.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,345,221.16	72,496,703.48
210201	Тэтгэврийн даатгал	44,557,761.54	51,247,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,241,779.60	5,325,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,146,383.67	4,260,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	945,390.67	1,065,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,453,905.68	10,598,803.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,005,569.18	59,978,439.74
210301	Гэрэл, цахилгаан	10,967,569.18	10,077,641.71
210302	Түлш, халаалт	32,914,125.00	30,342,585.09
210303	Цэвэр, бохир ус	18,123,875.00	19,558,212.94
2104	Хангамж, бараа материалын зардал	5,833,250.00	3,896,000.00
210401	Бичиг хэрэг	1,081,450.00	1,134,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	225,100.00	128,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,580,550.00	2,141,900.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	159,900.00	491,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	786,250.00	-
2105	Нормативт зардал	35,924,620.00	31,753,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,400.00	95,900.00
210502	Хоол, хүнс	35,891,220.00	31,657,630.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	754,200.00	2,530,200.00
210604	Урсгал засвар	754,200.00	2,530,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,745,268.00	411,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	737,268.00	411,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	185,758,507.39	97,526,194.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,281,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,758,507.39	96,244,494.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,320,189.66	2,678,540.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,120,189.66	2,678,540.71
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,120,189.66	2,678,540.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,762,708,184.61	(85,585,477.64)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,665,900.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5,665,900.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,665,900.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,757,042,284.61	(85,585,477.64)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,055,053,620.05	2,493,476,079.21	1,664,185,160.77	5,212,714,860.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,055,053,620.05	2,493,476,079.21	1,664,185,160.77	5,212,714,860.03
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(85,585,477.64)	(85,585,477.64)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,055,053,620.05	2,493,476,079.21	1,578,599,683.13	5,127,129,382.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	712,267,061.00	708,090,464.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	712,267,061.00	708,090,464.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	636,759,300.00	641,016,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	636,759,300.00	641,016,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	315,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,422,500.00	64,477,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,422,500.00	64,477,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,085,261.00	1,782,064.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7,085,261.00	1,782,064.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	712,923,529.00	708,090,464.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	712,923,529.00	708,090,464.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	704,518,078.34	703,629,859.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,547,500.00	526,336,569.55
210101	Үндсэн цалин	343,261,240.62	350,542,085.80
210102	Нэмэгдэл	132,587,446.03	133,601,066.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,406,995.82	1,137,200.00
210104	Урамшуулал	36,291,817.53	41,056,217.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,345,221.16	72,548,300.00
210201	Тэтгэврийн даатгал	44,557,761.83	51,247,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,241,779.84	5,325,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,146,383.78	4,260,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	945,390.87	1,065,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,453,904.84	10,650,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,005,569.18	59,978,439.74
210301	Гэрэл, цахилгаан	10,967,569.18	10,562,194.03
210302	Түлш, халаалт	33,244,600.00	30,342,585.09
210303	Цэвэр, бохир ус	17,793,400.00	19,073,660.62
2104	Хангамж, бараа материалын зардал	7,819,300.00	5,720,300.00
210401	Бичиг хэрэг	193,400.00	495,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	156,700.00	128,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,122,300.00	4,511,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	346,900.00	584,900.00
2105	Нормативт зардал	36,705,620.00	33,584,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206,200.00	90,700.00

210502	Хоол, хүнс	35,431,820.00	32,622,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,067,600.00	871,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,229,700.00	2,275,200.00
210604	Урсгал засвар	6,229,700.00	2,275,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,664,468.00	411,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	656,468.00	411,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,200,700.00	2,774,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,200,700.00	2,774,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,405,450.66	4,460,604.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,285,261.00	1,782,064.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	7,085,261.00	1,782,064.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	187,230.82	2,223,360.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,230.82	2,223,360.26
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	932,958.84	455,180.45
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	932,958.84	455,180.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(656,468.00)	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(656,468.00)	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	705,493,400.00	702,814,859.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	705,493,400.00	702,814,859.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	705,493,400.00	702,814,859.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,521,000.00	526,336,569.55
210101	Үндсэн цалин	283,245,100.00	350,542,085.80
210102	Нэмэгдэл	197,092,200.00	133,601,066.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,209,500.00	1,137,200.00
210104	Урамшуулал	41,974,200.00	41,056,217.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,548,300.00	72,548,300.00
210201	Тэтгэврийн даатгал	51,247,500.00	51,247,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,325,200.00	5,325,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,260,200.00	4,260,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,065,000.00	1,065,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,650,400.00	10,650,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,192,800.00	59,978,439.74
210301	Гэрэл, цахилгаан	11,154,800.00	10,562,194.03

210302	Түлш, халаалт	33,244,600.00	30,342,585.09
210303	Цэвэр, бохир ус	17,793,400.00	19,073,660.62
2104	Хангамж, бараа материалын зардал	4,980,300.00	4,980,300.00
210401	Бичиг хэрэг	157,800.00	255,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	127,800.00	128,400.00
210404	Ном, хэвлэл	98,700.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,111,900.00	4,011,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	484,100.00	584,900.00
2105	Нормативт зардал	33,694,000.00	33,584,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,700.00	90,700.00
210502	Хоол, хүнс	32,732,200.00	32,622,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	871,100.00	871,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,284,200.00	2,275,200.00
210604	Урсгал засвар	2,284,200.00	2,275,200.00
2107	Томилолт, зочны зардал	161,300.00	-
210702	Дотоод албан томилолт	161,300.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	336,800.00	336,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	336,800.00	336,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,774,700.00	2,774,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,774,700.00	2,774,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	705,493,400.00	702,814,859.29
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	641,016,400.00	640,561,219.55
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	641,016,400.00	640,561,219.55
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,477,000.00	62,253,639.74
132001	Орон нутгийн төсвөөс	64,477,000.00	62,253,639.74
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44.00	44.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	30.00	30.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44.00	44.00
650004	СЕБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	28.00	28.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16.00	16.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	815,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	815,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	740,000.00
210401	Бичиг хэрэг	240,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	815,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Хэрлэнзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд тодорхойлсон бага насны хүүхдийн өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах сургалтын байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 708,090.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,621.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,434.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 85,585.5 мянган төгрөгөөр буюу 1,6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Бараа материал	122,873.2	127,810.1	4,936.9
Үндсэн хөрөнгө	5,089,841.5	4,999,267.5	-90,574.0
Нийт хөрөнгө	5,212,714.8	5,127,129.3	-85,585.5
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,212,714.8	5,127,129.3	-85,585.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,212,714.8	5,127,129.3	-85,585.5

Бараа материалын данс 127,810.1 мянган төгрөг болж 4,936.9 мянган төгрөгөөр өссөн нь зарцуулаагүй үлдсэн бараа материалын үлдэгдлээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,999,267.5 мянган төгрөг болж 90,574.0 мянган төгрөгөөр буурсан нь элдэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,127,129.3 мянган төгрөг болж 85,585.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 796,681.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 796,681.6 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас ирүүлсэн төсвийн төслийг 91,188.2 мянган төгрөгөөр бууруулан 705,493.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 641,016.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 64,477.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, урсгал үйл ажиллагаанд 702,814.9 мянган төгрөгийг зарцуулж, 2,223.3 мянган төгрөгийг улсын төсөвт, 455.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 702,814.8 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд 815.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч 740.0 мянган төгрөгийг хангамж бараа материалын зардалд, 75.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансанд мэдээлвэл зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар итгэл үзүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,284.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,233.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 51.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа гараагүй.

4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд “Соёлыг түгээе” сарын аян зохион байгуулж шторк, боршур хэвлүүлэх зардалд 285.0 мянган төгрөг, хог хаягдал ялгах савны зардалд 643.5 мянган төгрөг, шагналын зардалд 304.7 мянган төгрөг, нийтдээ 1,233.2 мянган төгрөгийн зардал гаргаж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3.-д “.....цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

4.3 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 51.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага үүссэн байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдан авлага, өр төлбөр үүсгэхгүй байхаар зохион байгуулж ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэг	1	1,284.7	0	0	0	0	1	1,233.2	1	51.5



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 22/82 ОРА-2022/41/НА-СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Соёлыг түгээе” сарын аян зохион байгуулж шторк, боршур хэвлүүлэх зардалд 285.0 мянган төгрөг, хог хаягдал ялгах савны зардалд 643.5 мянган төгрөг, шагналын зардалд 304.7 мянган төгрөг, нийтдээ 1,233.2 мянган төгрөгийн зардал гаргаж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3.-д “.....цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн 7 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Х.Энхсайхан, нягтлан бодогч С.Нарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: О.ХЭРЛЭНЗАЯА